

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.020.40

Мод үржүүлгийн талбай сонгох арга. Техникийн шаардлага	MNS 6138 : 2010
Site selection for open nursery. Technical requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 21 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2010 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь ойжуулалт, хот сууринг цэцэрлэгжүүлэх, ойн зурвас байгуулах зэрэгт зориулсан мод, сөөгний тарьц, суулгац ургуулах зорилгоор мод үржүүлгийн газар байгуулах талбайг сонгоход хамаарна.

2 Нэр томъёо ба тодорхойлолт

2.1

Мод, сөөгний тарьц

суулгацын материал болгон ашиглах зорилгоор үрээр ургуулсан, ихэвчлэн 1-3 настай мод, сөөг,

2.2

Мод, сөөгний суулгац

шилжүүлэн тарьсан тарьц болон мод, сөөгний ургал эрхтнээр ургуулсан суулгацын материал.

3 Талбай сонгох

Мод үржүүлгийн газар байгуулах талбайг сонгохдоо хөрс, усан хангамж, уур амьсгал зэрэг байгаль орчин болон эдийн засгийн нөхцлийг харгалзан үзнэ.

3.1 Байгаль орчны нөхцөл

3.1.1 Тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газрын талбай нь эдгээрийг шилжүүлэн ургуулах газрын хөрс, уур амьсгалын аль болох ойролцоо нөхцөлтэй газар байх ёстой.

3.1.2 Шилмүүст модны тарьц, суулгац ургуулах талбай нь тухайн зүйлийн модны ой ургасан газарт, уг ойн тархалтын хил зааг дотор байна.

3.1.3 Навчит мод, сөөгний тарьц, суулгац ургуулах талбай нь тухайн төрлийн модны байгаль дахь тархалтын хилийн хязгаарын дотор болон ургах орчны нөхцөлтэй ойролцоо газар байна.

3.1.4 Үржүүлгийн талбайн газрын гадрага тэгш байх ба (2-3) градусаас дээшгүй налуутай байна. Уулын дэвсэг хажуу газар бол 12 градус хүртэл налуутай байж болно.

MNS 6138 : 2010

3.1.5 Шилмүүст мод үржүүлгийн газрын талбайн налуу хажуу нь баруун, баруун хойт, хойт, зүүн хойт, зүүн зүгт чиглэсэн байвал зохино.

3.1.6 Талбай нь хүйтэн, халуун хуурай салхинаас хамгаалагдсан нөмөр газар байх ба эргэн тойрондоо хаалттай хонхор газар байж болохгүй. Цас, мөс, борооны усны үерт автагдахааргүй газар сонгоно.

3.1.7 Мод үржүүлгийн газар байгуулах талбайн хөрс шим тэжээлийн элементээр баялаг, үржил шимтэй үеийн зузаан 25-аас 40 см-ээс багагүй, хөнгөн ба дунд ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй, шүүрэлт сайтай байна. Ойн бүсэд сул чандруужсан элсэнцэр, хөнгөн шавранцар, бараан, хар шороон, хар хүрэн, ойт хээрт чандруужсан, хөнгөн шавранцар ба элсэнцэр бараан саарал, хар шороон, хар хүрэн; хээрт хөнгөн ширхэгийн бүрэлдэхүүнтэй хар хүрэн, хүрэн; цөлөрхөг хээрт элсэнцэр, цайвар хүрэн, говийн бор, хөрстэй газар байх нь тохиромжтой. Хөрсний PH 4,5-7,0 байна.

3.1.8 Сонгон авч байгаа үржүүлгийн талбайд хөрсний зүсэлт авч, үндсэн давхрагуудын физик агрохимийн шинж чанарыг тодорхойлох, услах усны химийн найрлагын шинжилгээ хийх ба хөнөөлт шавьж, элдэв өвчний халдвар байгаа эсэхийг судалсан байх ёстой.

3.1.9 Шавран, хүчтэй чандруужсан, хужирлаг, намагжсан, чулуурхаг, үндэслэг ишт хог ургамал ихтэй зэрэг хөрстэй газар болон илүүдэл ус тогтохоор нам дор газар, хөрсний усны түвшин ойр газарт мод үржүүлгийн газрыг сонгон авч болохгүй.

3.1.10 Мод үржүүлгийн газрын хөрсний доорх усны түвшин шавранцар, хүрэн, хар хүрэн хөрстэй бол 3-аас 4 м, элсэрхэг хөрстэй бол 1,5-аас 2,5 м-ийн гүнд байвал зохино.

3.1.11 Мод үржүүлгийн газрын талбайг услаж болох байнга ундрагатай, тасарч ширгэдэггүй гол, горхи, цэнгэг нуур, цөөрмийн усыг ашиглахаар түшиглэн байгуулна. Усгүй нөхцөлд өрмийн гүн худаг бүхий усалгааны систем байгуулна. Усны давсны хэмжээ (0,1-0,5) %-иас ихгүй байна.

3.2 Эдийн засгийн нөхцөл

3.2.1 Мод үржүүлгийн газрын талбай нь суулгац материалыг хэрэглэх газартаа ойр, жилийн аль ч улиралд саадгүй зорчих зам харилцаа сайтай байна.

3.2.2 Тарьц, суулгацыг хатаахгүй, хугалж гэмтээхгүйгээр хэрэглэгчид хүргэх, тээврийн илүү зардал гаргахгүй байх нөхцлийг хангасан байна.

3.2.3 Мод үржүүлгийн газар нь өөрийн төв байгууллага, мод, сөөгний үр болон бусад материал бэлтгэх, зөөх газартаа аль болох ойр байвал зохино.

3.2.4 Ажиллах хүчнээр хангагдах боломжтой, ажилчдын ахуй хангамж, ажиллах нөхцөл сайтай газар байна.

4 Мод үржүүлгийн газрын талбайг зохион байгуулах

4.1 Мод үржүүлгийн газрын талбайг хэмжээнээс нь хамааруулан 0,5-аас 1 га болон 3-аас 4 га-гаар хэсэгчилэн, голдуу тэгш өнцөгт талбайд хуваарилан зохион байгуулна.

4.2 Мод үржүүлгийн газар нь зорилго, үйлчлэх хугацаа, үйлдвэрийн чадамж зэргээсээ хамаарч үрийн хэсэг, бойжуулах хэсэг, эх ургамлын хэсэг, дендрарийн хэсэгтэй байж болно.

4.3 Талбайн зохион байгуулалтыг тарих модны төрөл, зүйл, гаргах үр, суулгац материалыг харгалзан тодорхой дараалалтай, бүрэн гүйцэд тасралтгүй ашиглахаар хийсэн байна.

4.4 Зам, суваг, шуудуу, хамгаалалтын ойн зурвас, аж ахуйн барилга байгууламж зэргийг нарийн төлөвлөж, зохион байгуулсан байна.

4.5 Мод үржүүлгийн газрын тарьц ургуулах хэсгийг услахад хамгийн ойрхон, суулгац бойжуулах хэсгийг услах боломжтой газарт байрлуулах ба үр, мөчир бэлтгэх эх ургамлын хэсгийг дээрх 2 хэсэгт тохирохооргүй газар буюу Мод үржүүлгийн газрын зах хэсэг, налуу газар, эсвэл үндсэн талбайн захаас холгүй газар байгуулж болно.

4.6 Хамгаалалтын ойн зурвас нь цаг уурын нөхцөл, газрын өндөр намаас шалтгаалан 3-аас 4 эгнээ шилмүүст, навчит мод, сөөг байна. Талбайн доторх хэсгүүдийн дундуур мод, сөөгөөр 1-ээс 2 эгнээ зурвас байгуулна. Зурвасны эгнээн дэх модны хооронд 2-оос 3 м, сөөгний хооронд 0,3-аас 0,5 м, эгнээний хооронд 2 м зайтай байна.

4.7 Мод үржүүлгийн газрын талбайн бүх замууд хоорондоо холбогдсон, үйлчилгээний машин, трактор чөлөөтэй эргэх, зөрөх боломжтой байна.

ТӨГСӨВ.